



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.3.02 № ЦАТ-11/04/02

танай__-ны №__-т

Г Хуулийн хэрэгжилтийг хангах тухай Г

Орон сууцны тухай хуулийн 7¹.1.4 дэх заалт, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 3.2-ыг үндэслэн Барилга, хот байгуулалтын яам, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын хэрэгжүүлж буй “Орон сууцны мэдээллийн сангийн вэб сайтыг хөгжүүлэх” ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь Барилга, хот байгуулалтын яамны төслийн багтай хамтран үл хөдлөх хөрөнгийн салбарын статистик мэдээллийг бодит цагийн горимоор бүрдүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Тус мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхэд тусгай зөвшөөрөлтэй зуучлалын байгууллагуудын холбогдох мэдээллийг уг санд төвлөрүүлэх, цаашид хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг тухай бүр нийлүүлэх шаардлага үүссэн бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т зааснаас бусад хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна” мөн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1-д “мэдээллийн эзний зөвшөөрлөөр” гэж тус тус заасан тул доорх мэдээллийг Хороонд ирүүлж хамтран ажиллана уу. Үүнд:

1. Хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг Хороо болон бусад төрийн байгууллагад дамжуулахыг зөвшөөрсөн эсэх талаар харилцагчтай байгуулах гэрээнд холбогдох зохицуулалтыг тусган ажиллах (банкны зээлийн гэрээнд тусгасны адил);
2. Брокер, агент, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нарын хязгаарлалттай мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны цахим хуудсаар (www.frc.mn) дамжуулан нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн эсэх талаарх албан бичгийг хавсралтын дагуу брокер, агент, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан тус бүрийн гарын үсгээр баталгаажуулан 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд realestate-heregilt@frc.mn цахим шууданд ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай.



Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд мэдээлэл
байршуулахыг зөвшөөрсөн эсэх тухай

“.....” ХХК

Эрхэлж буй албан тушаал	Овог	Нэр	Хорооны цахим хуудсанд:			Гарын үсэг
			Овог, нэрээ байршуулахыг зөвшөөрсөн эсэх	Цахим шуудангийн хаяг байршуулахыг зөвшөөрсөн эсэх	Гар утасны дугаар байршуулахыг зөвшөөрсөн эсэх	
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан						
Брокер						
Агент						

Тохирох сонголтыг хийж ✓ тэмдгээр тэмдэглэнэ үү.

Танай компанид ажилладаг нийт брокер, агент, МУТСТмХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны мэдээллийг бүрэн бичнэ үү.

